

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН 2010 ОНЫ ШҮҮН
ТАСЛАХ АЖИЛЛАГААНЫ НЭГДСЭН ДҮНГИЙН
ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2011 оны 01 дүгээр
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

Нэг. Эрүүгийн шүүн таслах ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд 2010 онд 9638 хүнд холбогдох 6372 эрүүгийн хэрэг хүлээн авч, 956 хүнд холбогдох 515 эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцааж, 13 хүнд холбогдох 11 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, шүүгдэгч, хохирогч эвлэрснээр 475, цагаатгах тогтоолоор 224 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, 7292 хүнд холбогдох 5460 хэргийг таслан шийдвэрлэж, 678 холбогдогчтой 386 хэргийн үлдэгдэлтэй байна.

Өнгөрсөн оноос шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 1,0 хувиар өсч, ял шийтгүүлэгчид 2,9 хувиар буурчээ.

Анхан шатны шүүхээр 2010 онд таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн тоо, ял шийтгүүлэгчдийг өмнөх онтой нь харьцуулж үзвэл:

| Д/д | Шүүх | Эрүүгийн хэргийн тоо | | | | Ял шийтгүүлэгчдийн тоо | | | |
|-----|------------|----------------------|-------------|----------------|-------------|------------------------|-------------|----------------|--------------|
| | | Бүтэн жилд | | Өсөлт, бууралт | | Бүтэн жилд | | Өсөлт, бууралт | |
| | | 2009 он | 2010 он | тоо | хувь | 2009 он | 2010 он | тоо | хувь |
| 1 | Архангай | 76 | 87 | 11 | 14.47 | 131 | 130 | -1 | -0.76 |
| 2 | Баян-Өлгий | 89 | 62 | -27 | -30.34 | 100 | 79 | -21 | -21.00 |
| 3 | Баянхонгор | 161 | 154 | -7 | -4.35 | 165 | 188 | 23 | 13.94 |
| 4 | Булган | 97 | 74 | -23 | -23.71 | 133 | 102 | -31 | -23.31 |
| 5 | Говь-Алтай | 45 | 64 | 19 | 42.22 | 63 | 80 | 17 | 26.98 |
| 6 | Говьсүмбэр | 34 | 46 | 12 | 35.29 | 34 | 46 | 12 | 35.29 |
| 7 | Дархан-Уул | 259 | 247 | -12 | -4.63 | 380 | 339 | -41 | -10.79 |
| 8 | Дорнод | 136 | 125 | -11 | -8.09 | 166 | 157 | -9 | -5.42 |
| 9 | Дорноговь | 208 | 232 | 24 | 11.54 | 285 | 298 | 13 | 4.56 |
| 10 | Дундговь | 71 | 68 | -3 | -4.23 | 104 | 78 | -26 | -25.00 |
| 11 | Завхан | 87 | 68 | -19 | -21.84 | 119 | 81 | -38 | -31.93 |
| 12 | Орхон | 167 | 150 | -17 | -10.18 | 259 | 236 | -23 | -8.88 |
| 13 | Өвөрхангай | 125 | 164 | 39 | 31.20 | 183 | 221 | 38 | 20.77 |
| 14 | Өмнөговь | 116 | 117 | 1 | 0.86 | 147 | 160 | 13 | 8.84 |
| 15 | Сүхбаатар | 105 | 114 | 9 | 8.57 | 117 | 122 | 5 | 4.27 |
| 16 | Сэлэнгэ | 338 | 284 | -54 | -15.98 | 540 | 389 | -151 | -27.96 |
| 17 | Төв | 181 | 170 | -11 | -6.08 | 232 | 215 | -17 | -7.33 |
| 18 | Увс | 166 | 143 | -23 | -13.86 | 246 | 195 | -51 | -20.73 |
| 19 | Ховд | 125 | 104 | -21 | -16.80 | 142 | 147 | 5 | 3.52 |
| 20 | Хөвсгөл | 124 | 111 | -13 | -10.48 | 154 | 138 | -16 | -10.39 |
| 21 | Хэнтий | 174 | 155 | -19 | -10.92 | 224 | 191 | -33 | -14.73 |
| 22 | Нийслэл | 2523 | 2721 | 198 | 7.85 | 3589 | 3700 | 111 | 3.09 |
| | Дүн | 5407 | 5460 | 53 | 0.98 | 7513 | 7292 | -221 | -2.94 |

байдалтай байна.

Таслан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг Дундговь, Баянхонгор, Дархан-Уул, Төв, Дорнод, Орхон, Хөвсгөл, Хэнтий, Увс, Сэлэнгэ, Ховд, Завхан, Булган, Баян-Өлгий аймагт 4,2 – 30,3 хувиар буурч, Өмнөговь, Нийслэл, Сүхбаатар, Дорноговь, Архангай, Өвөрхангай, Говьсүмбэр, Говь-Алтай аймагт 0,9 – 42,2 хувиар нэмэгджээ.

Ял шийтгүүлэгчид Архангай, Дорнод, Төв, Орхон, Хөвсгөл, Дархан-Уул, Хэнтий, Увс, Баян-Өлгий, Булган, Дундговь, Сэлэнгэ, Завхан аймагт 0,8 – 31,9 хувиар буурч, Нийслэл, Ховд, Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Говьсүмбэр аймагт 3,1 – 35,3 хувиар өссөн байна.

Анхаарал татаж байгаа эрүүгийн хэргийг авч үзвэл:

| Д/д | Хэргийн төрөл | Хэргийн тоо | | | | Ял шийтгүүлэгчид | | | |
|-----|-----------------------------------------------------------------------------------------------|-------------|---------|----------------|-------|------------------|---------|----------------|-------|
| | | Бүтэн жилд | | Өсөлт, бууралт | | Бүтэн жилд | | Өсөлт, бууралт | |
| | | 2009 он | 2010 он | тоо | хувь | 2009 он | 2010 он | тоо | хувь |
| 1 | Хүнийг санаатай алах гэмт хэрэг | 219 | 244 | 25 | 11.4 | 239 | 280 | 41 | 17.2 |
| 2 | Бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг | 284 | 330 | 46 | 16.2 | 295 | 344 | 49 | 16.6 |
| 3 | Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг | 1349 | 1235 | -114 | -8.5 | 2195 | 1903 | -292 | -13.3 |
| 4 | Танхайрах гэмт хэрэг | 746 | 807 | 61 | 8.2 | 1060 | 1202 | 142 | 13.4 |
| 5 | Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг | 284 | 250 | -34 | -12.0 | 620 | 488 | -132 | -21.3 |
| 6 | Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг гэмт хэрэг | 712 | 751 | 39 | 5.5 | 711 | 770 | 59 | 8.3 |
| 7 | Албан тушаалын гэмт хэрэг | 10 | 16 | 6 | 60.0 | 20 | 27 | 7 | 35.0 |
| 8 | Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг | 66 | 57 | -9 | -13.6 | 78 | 83 | 5 | 6.4 |

байдалтай байна.

Эдгээр төрлийн гэмт хэрэг таслан шийдвэрлэсэн нийт хэргийн 67,6 хувь, ял шийтгүүлэгчдийн 69,9 хувийг эзэлж байгаа бол бусдын эд хөрөнгийг хулгайлах, танхайрах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн нийлбэр нь нийт хэргийн 51,2, ял шийтгүүлэгчдийн 53,1 хувийг эзэлж байна.

Өнгөрсөн оныхоос бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 8,5, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх гэмт хэрэг 12,0, эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэрэг 13,6 хувиар буурсан бол, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 5,5, танхайрах гэмт хэрэг 8,2, бусдыг санаатай алсан гэмт хэрэг 11,4, бусдын бие махбодид хүнд гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг 16,2, албан тушаалын гэмт хэрэг 60,0 хувиар тус тус өсчээ.

Ял шийтгүүлэгчдийн байдлыг авч үзвэл:

| Д/д | Үзүүлэлт | Бүтэн жил | | Өсөлт, бууралт | |
|---------------------------|-------------------------------|-----------|---------|----------------|--------|
| | | 2009 он | 2010 он | Тоо | Хувиар |
| Ял шийтгүүлэгчид. Үүнээс: | Насанд хүрээгүй этгээд | 386 | 451 | 65 | 16.8 |
| | Эмэгтэйчүүд | 656 | 612 | -44 | -6.7 |
| | Гадаадын харъяат | 26 | 30 | 4 | 15.4 |
| | Урьд ял шийтгүүлсэн | 1637 | 1645 | 8 | 0.5 |
| | Гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн | 1314 | 1407 | 93 | 7.1 |
| | Согтуугаар гэмт хэрэг үйлдсэн | 1610 | 1512 | -98 | -6.1 |
| | Ажил, сургуульгүй хүмүүс | 5047 | 4881 | -166 | -3.3 |

байдалтай байна.

Гэмт хэргийн улмаас нийтдээ 26 тэрбум 312 сая төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирч, 535 хүний амь хохирч, 2284 хүний биед (хүнд, хүндэвтэр, хөнгөн) гэмтэл учирчээ.

Шүүхээс оногдуулсан ял шийтгэлийн байдлыг авч үзвэл:

| Д/д | Төрөл | Бүтэн жил | | Нийт ялын дотор эзлэх хувь | |
|------------------------------|---------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|-------------|----------------------------|-------------|
| | | 2009 он | 2010 он | 2009 он | 2010 он |
| Нийт ял шийтгүүлэгчид | | 7513 | 7292 | | |
| 1 | <i>Хорих ялаар бүгд: Үүнээс</i> | 5742 | 5537 | 76.4 | 75.9 |
| | а/ Хорих ялыг биечлэн эдлүүлсэн | 3074 | 2543 | | |
| | б/ Тэнссэн | 2013 | 2444 | | |
| | в/ Эрүүгийн хуулийн 62, 63-р зүйлээр шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан Үүнээс: | 305 | 434 | | |
| | а/Насанд хүрээгүй этгээд | 226 | 353 | | |
| | б/Жирэмсэн эмэгтэй 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэг | 79 | 81 | | |
| | г/ Өршөөл үзүүлсэн | 350 | 116 | | |
| | 2 | <i>Хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн: Үүнээс</i> | 1696 | 1668 | 22.6 |
| а/ Торгох ял | 260 | 281 | | | |
| б/ Албадан ажил хийлгэх ял | 337 | 376 | | | |
| в/ Баривчлах ял | 1099 | 1011 | | | |
| 3 | <i>Бусад ял</i> | 11 | 19 | 0.1 | 0.3 |
| 4 | <i>Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ</i> | 64 | 68 | 0.9 | 0.9 |

байдалтай байна.

Ял шийтгүүлэгчдийн 75,9 хувьд хорих, 5,1 хувьд албадан ажил хийлгэх, 13,9 хувьд баривчлах, 0,3 хувьд бусад ял оногдуулж, насанд хүрээгүй 68 этгээдэд (0,9 хувь) хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авчээ. Мөн 3,9 хувь буюу 281 хүнийг 1 тэрбум 247 сая төгрөгөөр торгох ял оногдуулжээ.

2543 хүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлсэн нь хорих ял шийтгүүлэгчдийн 45,9 хувь нь болж байна.

Хорих ялыг биечлэн эдлүүлсэн ба баривчлах ялаар шийтгүүлсэн хүн 3554 байгаа нь нийт ял шийтгүүлэгчдийн 48,7 хувийг эзэлж байна.

Шүүх эд хөрөнгө хураах нэмэгдэл ялыг 364 хүнд хэрэглэж 855,7 сая төгрөг гаргуулсны дээр, тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хасах ялыг 468 хүнд нэмэгдэл ялын чанартайгаар оногдуулжээ.

Шүүх хорих ял биечлэн эдлүүлсэн 2543 хүний 63,1 хувийг жирийн, 35,3 хувийг чанга, 1,4 хувийг онцгой, 0,2 хувийг гяндангийн дэглэмд ял эдлүүлэхээр тогтоожээ.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар эрүүгийн 2129 хэрэг хүлээн авснаас 2016 хэргийг хянан шийдвэрлэж, 1037 буюу 51,4 хувьд нь захирамж, тогтоолыг хэвээр үлдээж, 476 буюу 23,6 хувьд нь захирамж, тогтоолд өөрчлөлт оруулж, 503 буюу 25,0 хувьд нь захирамж, тогтоолыг хүчингүй болгожээ. Оны эцэст 69 хэргийн үлдэгдэлтэй гарав. 44 хэргийн хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдол, эсэргүүцлээсээ татгалзан буцаан авчээ.

| Үзүүлэлт | Бүтэн жилд | | Хянагдсан хэрэгт эзлэх хувь | | |
|-------------------------|------------|---------|-----------------------------|---------|---------------|
| | 2009 он | 2010 он | 2009 он | 2010 он | зөрүү /+/, -/ |
| Хянан шийдвэрлэсэн бүгд | 2110 | 2016 | | | |
| Хэвээр үлдээсэн | 1089 | 1037 | 51.6 | 51.4 | - 0.2 |
| Өөрчлөлт оруулсан | 554 | 476 | 26.3 | 23.6 | - 2.7 |
| Хүчингүй болгосон | 467 | 503 | 22.1 | 25.0 | + 2.9 |
| Үлдэгдэл | 65 | 69 | | | |

Давж заалдах шатны шүүх 979 тогтоолыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 48,6 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар эрүүгийн 726 хэрэг хүлээн авснаас, 551 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсний 207 нь прокурорын дүгнэлтээр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянуулах тухай хүсэлтийг шийдвэрлэсэн хэрэг байна. Үүний 191 нь цагаатгалын хэрэг. Мөн 141 хэргийг хянаж, хариу өгсөн ба эхний хагас жилд 34 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хяналтын шатны шүүхээр хянан хэлэлцэгдсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоол, магадлалын 208 буюу 37,7 хувийг хэвээр үлдээж, 50 буюу 9,1 хувийг өөрчилж, 293 буюу 53,2 хувийг хүчингүй болгожээ.

| | | Бүтэн жилд | | Хянагдсан хэрэгт эзлэх хувь | | |
|----------------------------------------------------------------------|-------------------|------------|------------|-----------------------------|---------|---------------|
| | | 2009 он | 2010 он | 2009 он | 2010 он | зөрүү +/-,-/- |
| Хүлээн авсан хэрэг | | 687 | 726 | | | |
| Хянаад хариу өгсөн хэрэг | | 132 | 141 | | | |
| Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс: | | 546 | 551 | | | |
| Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг | | 485 | 331 | | | |
| Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн | | 12 | 13 | | | |
| Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн | | 49 | 207 | | | |
| Үүнээс: | Хэвээр үлдээсэн | 234 | 208 | 42,9 | 37,7 | -5,2 |
| | Өөрчлөлт оруулсан | 122 | 50 | 22,3 | 9,1 | -13,2 |
| | Хүчингүй болгосон | 190 | 293 | 34,8 | 53,2 | +14,8 |
| Үлдэгдэл | | 9 | 34 | | | |

Хяналтын шатны шүүх 343 тогтоол, магадлалыг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 62,3 хувийг эзэлж байна.

Хоёр. Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Анхан шатны шүүхүүд 48170 нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авч, 8303 нэхэмжлэлийг хуульд заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах, буцаах, харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх зэрэг ажиллагааг хийж, бүгд 35787 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 35 хэргээр буюу 0,1 хувиар буурсан байна. Оны эцэст 4080 хэргийн үлдэгдэлтэй гарав.

Хянан шийдвэрлэсэн нийт 35787 хэргийн 13994 буюу **39,1** хувийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд заасан хялбаршуулсан журмаар, 20943 буюу 58,5 хувийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцжээ.

Анхан шатны шүүхээр 2010 онд хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг урьд онтой харьцуулж үзвэл:

| Д/д | Шүүх | Бүтэн жилд | | өсөлт, бууралт | |
|-----|------------|------------|---------|----------------|--------|
| | | 2009 он | 2010 он | тоо | хувь |
| 1 | Архангай | 949 | 843 | -106 | -11.17 |
| 2 | Баян-Өлгий | 1048 | 935 | -113 | -10.78 |
| 3 | Баянхонгор | 1052 | 853 | -199 | -18.92 |
| 4 | Булган | 846 | 731 | -115 | -13.59 |
| 5 | Говь-Алтай | 782 | 678 | -104 | -13.30 |
| 6 | Говьсүмбэр | 496 | 292 | -204 | -41.13 |
| 7 | Дархан-Уул | 1958 | 2062 | 104 | 5.31 |
| 8 | Дорнод | 1134 | 1056 | -78 | -6.88 |
| 9 | Дорноговь | 1082 | 887 | -195 | -18.02 |
| 10 | Дундговь | 529 | 566 | 37 | 6.99 |
| 11 | Завхан | 954 | 924 | -30 | -3.14 |

| | | | | | |
|----|------------|--------------|--------------|------------|--------------|
| 12 | Орхон | 1470 | 1419 | -51 | -3.47 |
| 13 | Өвөрхангай | 1565 | 1768 | 203 | 12.97 |
| 14 | Өмнөговь | 594 | 553 | -41 | -6.90 |
| 15 | Сүхбаатар | 848 | 689 | -159 | -18.75 |
| 16 | Сэлэнгэ | 1676 | 1520 | -156 | -9.31 |
| 17 | Төв | 1307 | 1404 | 97 | 7.42 |
| 18 | Увс | 672 | 686 | 14 | 2.08 |
| 19 | Ховд | 1053 | 1599 | 546 | 51.85 |
| 20 | Хөвсгөл | 1717 | 1925 | 208 | 12.11 |
| 21 | Хэнтий | 1826 | 974 | -852 | -46.66 |
| 22 | Нийслэл | 12264 | 13423 | 1159 | 9.45 |
| | Дүн | 35822 | 35787 | -35 | -0.10 |

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэрэг Увс, Дархан-Уул, Дундговь, Төв, Нийслэл, Хөвсгөл, Өвөрхангай, Ховд аймагт 2,1 – 51,9 хувиар нэмэгджээ. Харин Завхан, Орхон, Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ, Баян-Өлгий, Архангай, Говь-Алтай, Булган, Дорноговь, Сүхбаатар, Баянхонгор, Говьсүмбэр, Хэнтий аймагт 3,1 – 46,7 хувиар буурчээ.

Хянан шийдвэрлэсэн иргэний хэргийг эрх зүйн төрлөөр авч үзвэл:

| төрөл | Бүтэн жилд | | Нийт хэрэгт эзлэх хувь | | Зөрүү /+,/-/ |
|-------------------------------------------------------------------------------------------|--------------|--------------|------------------------|---------|-----------------|
| | 2009 он | 2010 он | 2009 он | 2010 он | |
| Нийт иргэний хэрэг | 35822 | 35787 | | | |
| Иргэний эрх зүйн маргаан | 15508 | 14834 | 43,3 | 41,5 | -1,8 |
| Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар | 11137 | 12159 | 31,1 | 34,0 | +2,9 |
| Гэр бүлийн эрх зүйн маргаан | 4294 | 4732 | 12,0 | 13,2 | +1,2 |
| Хөдөлмөрийн эрх зүйн маргаан | 967 | 978 | 2,7 | 2,7 | - |
| Бусад эрх зүйн маргаан: Үүнээс: | 3916 | 3084 | 10,9 | 8,6 | -2,3 |
| Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиар | 63 | 33 | | | |
| Дампуурлын тухай хуулиар | 1 | 1 | | | |
| Компаний тухай хуулиар | 13 | 11 | | | |
| Нийгмийн даатгалын багц хуулиар | 401 | 254 | | | |
| Патентийн тухай хуулиар | 2 | 2 | | | |
| Зохиогчийн эрхийн тухай хуулиар | 2 | 0 | | | |
| Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулиар | 1 | 4 | | | |
| Төрийн албаны тухай хуулиар | 10 | 9 | | | |
| Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулиар | 123 | 85 | | | |
| Бусад хуулиар | 3300 | 2685 | | | |

Нийт хэрэгт иргэний эрх зүйн маргаан 41,5, иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн маргаан 34,0, гэр бүлийн эрх зүйн маргаан 13,2, хөдөлмөрийн эрх зүйн маргаан 2,7 хувийг тус тус эзэлж байна.

Аймаг, нийслэлийн шүүхүүд давж заалдах журмаар 2245 хэрэг хүлээн авснаас 2102 хэргийг хянан шийдвэрлэж, үүнээс 1134 буюу 54,0 хувьд нь шийдвэрийг хэвээр үлдээж, 543 буюу 25,8 хувьд нь шийдвэрт өөрчлөлт оруулж, 425 буюу 20,2 хувьд нь шийдвэрийг хүчингүй болгож, оны эцэст 98 хэргийн үлдэгдэлтэй гарав. 15 хэрэг нь давж заалдах гомдлыг хэлэлцэхээс татгалзаж, 30 хэргийн хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдол, эсэргүүцлээсээ татгалзан буцаан авчээ.

| Үзүүлэлт | Бүтэн жилд | | Хянагдсан хэрэгт эзлэх хувь | | |
|-------------------------|-------------|-------------|-----------------------------|---------|---------------|
| | 2009 он | 2010 он | 2009 он | 2010 он | зөрүү /+/,/-/ |
| Хянан шийдвэрлэсэн бүгд | 2006 | 2102 | | | |
| Хэвээр үлдээсэн | 965 | 1134 | 48,1 | 54,0 | +5,9 |
| Өөрчлөлт оруулсан | 597 | 543 | 29,8 | 25,8 | -4,0 |
| Хүчингүй болгосон | 444 | 425 | 22,1 | 20,2 | -1,9 |
| Үлдэгдэл | 81 | 98 | | | |

Давж заалдах шатны шүүх 968 шийдвэрийг өөрчилж, хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 46,1 хувийг эзэлж байна.

Хяналтын шатны журмаар иргэний 1334 хэрэг хүлээн авч, 257-г хянан хариу өгч, 1025 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн байна. Үүнээс шийдвэр, магадлалын 615 буюу 60,0 хувийг хэвээр үлдээж, 248 буюу 24,2 хувийг өөрчилж, 162 буюу 15,8 хувийг нь хүчингүй болгож, 52 хэргийн үлдэгдэлтэй гарав. Хянан шийдвэрлэсэн нийт 1025 хэргээс 3 хэргийг Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар, 38 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ.

| | Бүтэн жилд | | Хянагдсан хэрэгт эзлэх хувь | | | |
|----------------------------------------------------------------------|-------------------|-------------|-----------------------------|---------|---------------|------|
| | 2009 он | 2010 он | 2009 он | 2010 он | зөрүү /+/,/-/ | |
| Хүлээн авсан хэрэг | 1060 | 1334 | | | | |
| Хянаад хариу өгсөн хэрэг | 192 | 257 | | | | |
| Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс: | 803 | 1025 | | | | |
| Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг | 746 | 984 | | | | |
| Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хянан шийдвэрлэсэн | 1 | 3 | | | | |
| Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах хүсэлтийг шийдвэрлэсэн | 56 | 38 | | | | |
| Үүнээс | Хэвээр үлдээсэн | 467 | 615 | 58,2 | 60,0 | +1,8 |
| | Өөрчлөлт оруулсан | 221 | 248 | 27,5 | 24,2 | -3,3 |
| | Хүчингүй болгосон | 115 | 162 | 14,3 | 15,8 | +1,5 |
| Үлдэгдэл | 65 | 52 | | | | |

Хяналтын шатны шүүх 410 шийдвэр, магадлалыг өөрчилж хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 40,0 хувийг эзэлж байна.

Гурав. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар

Захиргааны хэргийн шүүхүүд 2010 онд 1625 нэхэмжлэл, гомдол хүлээн авч, 356 нэхэмжлэлийг Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэлээр харъяаллын дагуу зохих байгууллагад шилжүүлэх буюу захиргааны журмаар урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг хангуулахаар нэхэмжлэгчид нь буцааж, 1031 хэргийг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 43 хэргээр буюу 4.0 хувиар буурчээ.

Оны эцэст 238 хэргийн үлдэгдэлтэй гарсны дотор хуульд заасан үндэслэлээр 36 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, 58 хэргийн шүүх хуралдааныг хойшлуулж, 144 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

2010 онд хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг шүүх тус бүрээр үзүүлбэл:

| Д/д | Шүүх | Бүтэн жилд | | Өсөлт, бууралт | |
|-----|------------|-------------|-------------|----------------|--------------|
| | | 2009 он | 2010 он | тоо | хувь |
| 1 | Архангай | 25 | 19 | -6 | -24.00 |
| 2 | Баян-Өлгий | 69 | 66 | -3 | -4.35 |
| 3 | Баянхонгор | 21 | 21 | 0 | 0.00 |
| 4 | Булган | 30 | 29 | -1 | -3.33 |
| 5 | Говь-Алтай | 14 | 11 | -3 | -21.43 |
| 6 | Говьсүмбэр | 15 | 9 | -6 | -40.00 |
| 7 | Дархан-Уул | 29 | 29 | 0 | 0.00 |
| 8 | Дорнод | 20 | 21 | 1 | 5.00 |
| 9 | Дорноговь | 22 | 18 | -4 | -18.18 |
| 10 | Дундговь | 10 | 12 | 2 | 20.00 |
| 11 | Завхан | 37 | 12 | -25 | -67.57 |
| 12 | Орхон | 65 | 39 | -26 | -40.00 |
| 13 | Өвөрхангай | 52 | 38 | -14 | -26.92 |
| 14 | Өмнөговь | 10 | 11 | 1 | 10.00 |
| 15 | Сүхбаатар | 40 | 24 | -16 | -40.00 |
| 16 | Сэлэнгэ | 26 | 21 | -5 | -19.23 |
| 17 | Төв | 29 | 31 | 2 | 6.90 |
| 18 | Увс | 12 | 22 | 10 | 83.33 |
| 19 | Ховд | 28 | 8 | -20 | -71.43 |
| 20 | Хөвсгөл | 50 | 34 | -16 | -32.00 |
| 21 | Хэнтий | 20 | 24 | 4 | 20.00 |
| 22 | Нийслэл | 450 | 532 | 82 | 18.22 |
| | Дүн | 1074 | 1031 | -43 | -4.00 |

байдалтай байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэрэг Дорнод, Төв, Өмнөговь, Нийслэл, Дундговь, Хэнтий, Увс аймагт 5,0 – 83,3 хувиар нэмэгдэж, Булган, Баян-Өлгий, Дорноговь, Сэлэнгэ, Говь-Алтай, Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Сүхбаатар, Орхон, Говьсүмбэр, Завхан, Ховд аймагт 3,3 – 71,4 хувиар буурчээ. Харин Баянхонгор, Дархан-Уул аймаг өмнөх оны мөн үетэй адил байна.

Хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг маргааны төрлөөр авч үзвэл,

| Маргааны төрөл | Бүтэн жилд | | Нийт хэрэгт эзлэх хувь | |
|-----------------------------------------------------------|-------------|-------------|------------------------|---------|
| | 2009 он | 2010 он | 2009 он | 2010 он |
| Нийт захиргааны хэрэг | 1074 | 1031 | | |
| Сонгуультай холбоотой маргаан | 69 | 38 | 6,4 | 3,7 |
| Төрийн албаны тухай хуулиар | 197 | 214 | 18,3 | 20,8 |
| Төрийн болон орон нутгийн өмчийн тухай маргаан | 9 | 9 | 0,9 | 0,9 |
| Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлтэй холбоотой маргаан | 71 | 69 | 6,6 | 6,7 |
| Газрын маргаан | 228 | 214 | 21,2 | 20,8 |
| Ашигт малтмалтай холбоотой маргаан | 61 | 76 | 5,7 | 7,4 |
| Татварын маргаан | 87 | 116 | 8,1 | 11,2 |
| Тендерийн маргаан | 34 | 35 | 3,2 | 3,3 |
| Бусад маргаан | 318 | 260 | 29,6 | 25,2 |

байдалтай байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим давж заалдах шатаар 573 хэрэг хүлээн авч, 521 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэнээс, 5 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэж, үүнээс 62,8 хувь буюу 327 шийдвэр, захирамжийг хэвээр үлдээж, 10,9 хувь буюу 57 шийдвэрт өөрчлөлт оруулж, 26,3 хувь буюу 137 шийдвэр захирамжийг хүчингүй болгож, оны эцэст 29 хэргийг үлдэгдэлтэй гарчээ. 23 хэргийн хувьд эрх бүхий этгээд гаргасан гомдлоосоо татгалзсан байна.

| Үзүүлэлт | Бүтэн жилд | | Хянагдсан хэрэгт эзлэх хувь | | | |
|-----------------------------------------------------------------|-------------------|------------|-----------------------------|---------|---------------|------|
| | 2009 он | 2010 он | 2009 он | 2010 он | зөрүү /+/, -/ | |
| Хүлээн авсан хэрэг | 521 | 573 | | | | |
| Хянаад хариу өгсөн хэрэг | 8 | 23 | | | | |
| Нийт шийдвэрлэсэн хэрэг Үүнээс: | 476 | 521 | | | | |
| Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг | 472 | 516 | | | | |
| Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан | 4 | 5 | | | | |
| Үүнээс: | Хэвээр үлдээсэн | 309 | 327 | 64,9 | 62,8 | -2,1 |
| | Өөрчлөлт оруулсан | 47 | 57 | 9,9 | 10,9 | +1,0 |
| | Хүчингүй болгосон | 120 | 137 | 25,2 | 26,3 | +1,1 |
| Үлдэгдэл | 37 | 29 | | | | |

Хяналтын шатны шүүх 427 хэрэг хүлээн авснаас 324 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 83 хэргийг хянан хариу өгч, одоо 20 хэргийн үлдэгдэлтэй байна. Хянан хэлэлцсэн 324 хэргээс 12 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан шийдвэрлэжээ. Хяналтын шатны шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн 324 хэргийн 67,0 хувь буюу 217 шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, 23,8 хувь буюу 77 шийдвэр, магадлалыг өөрчилж, 9,2 хувь буюу 30 шийдвэр, магадлалыг хүчингүй болгожээ.

| Үзүүлэлт | | Бүтэн жилд | | Хянагдсан хэрэгт эзлэх хувь | | |
|-----------------------------------------------------------------|-------------------|------------|------------|-----------------------------|---------|---------------|
| | | 2009 он | 2010 он | 2009 он | 2010 он | зөрүү /+/,/-/ |
| Хүлээн авсан хэрэг | | 338 | 427 | | | |
| Хянаад хариу өгсөн хэрэг | | 55 | 83 | | | |
| Нийт шийдвэрлэсэн хэрэг. Үүнээс: | | 241 | 324 | | | |
| Хуралдаанаар хянан шийдвэрлэсэн хэрэг | | 236 | 312 | | | |
| Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар шийдвэрлэсэн | | 0 | 0 | | | |
| Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шүүхийн шийдвэрийг хянасан | | 5 | 12 | | | |
| Үүнээс | Хэвээр үлдээсэн | 162 | 217 | 67.2 | 67,0 | -0,2 |
| | Өөрчлөлт оруулсан | 37 | 77 | 15.4 | 23,8 | +8,4 |
| | Хүчингүй болгосон | 42 | 30 | 17.4 | 9,2 | -8,2 |
| Үлдэгдэл | | 42 | 20 | | | |

Хяналтын шатны шүүх 107 шийдвэр, магадлалыг өөрчилж хүчингүй болгосон нь нийт хянагдсан хэргийн 33,0 хувийг эзэлж байна.

Дөрөв. Бусад асуудлаар

Анхан шатны шүүхүүд бүгд 11849 (-839) хүнд захиргааны арга хэмжээ авсны дотор 665 (-17) хүнийг 5.8 (-4.8) сая төгрөгөөр торгож, 11079 (-927) хүнд баривчлах шийтгэл ногдуулжээ.

Захиргааны зөрчил гаргасан этгээд, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч буюу өмгөөлөгчийн гаргасан гомдлоор захиргааны шийтгэл ногдуулсан 205 (+14) шийтгэврийг давж заалдах журмаар хянаснаас 134 буюу 65.4 хувьд хэвээр үлдээж, 61 буюу 29.8 хувьд өөрчлөлт оруулж, 10 буюу 4.8 хувийг хүчингүй болгожээ.

Тайлангийн хугацаанд шүүхүүд ялтныг хорих ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах тухай 1326 (-133) материалыг хянан хэлэлцэж, 12 (-10) санал дүгнэлтийг хэрэгсэхгүй болгож, 826 (-1) хоригдлыг эдлээгүй үлдсэн хорих ялаас нь тэнсэн суллаж, 8 (-32) хоригдлын хорих ялыг хорихоос өөр төрлийн хөнгөн ялаар сольж, 480 (-92) хоригдлын ял эдлэх дэглэмийг өөрчилжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58, 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 853 (-202) сэжигтнийг баривчлах тухай материалыг хүлээн авч, 797 (-197) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 56 (-5) сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлд зааснаар 2391 (-577) хүнийг сэжигтнээр, 2527 (-660) хүнийг яллагдагчаар цагдан хорьж, 262 (-66) хүнд цагдан хорих зөвшөөрөл олгохоос татгалзсан байна.

Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх явцад улсын тэмдэгтийн хураамжид 2 тэрбум 426,8 (-231) сая төгрөг, үүнээс анхан шатны шүүх 1 тэрбум 970 (-79,0) сая төгрөг, давж заалдах шатны шүүх 340,2 (-102,0) сая төгрөг, хяналтын шатны шүүх 116,6 (-47,8) сая төгрөгийг улс, орон нутгийн орлогод оруулахаар шийдвэрлэв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан үндэслэлээр анхан шатны шүүхээс 447,4 (-79,2) сая төгрөг, давж заалдах шатны шүүхээс 220,3 (-23,6) сая төгрөг, хяналтын шатны шүүхээс 106.4 (+89,0) сая төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг зохигчдод буцаан олгохоор шийдвэрлэсэн байна.

Анхан шатны шүүхүүд нийт 71802 (-1781) хэрэг, маргааныг шийдвэрлэсний дотор эрүүгийн 6264 (+8), иргэний 44146 (-56), захиргааны 1387 (-109) хэрэг, 11849 (-839) захиргааны зөрчил, ялтныг ял эдлэхээс хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, үлдсэн ялыг өөр төрлийн хөнгөн ялаар солих тухай 1326 (-133) хүсэлт, 6886 (-652) хүнд баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох эсэх тухай асуудал хэлэлцжээ.

Ерөнхий харъяаллын анхан шатны шүүх болох сум, сум дундын шүүхийн нэг шүүгч дунджаар 239, дүүргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 349 хэрэг маргаан хянан шийдвэрлэсэн байна.

Аймгийн Захиргааны хэргийн шүүхийн нэг шүүгч дунджаар 14, нийслэлийн захиргааны хэргийн нэг шүүгч дунджаар 91 хэрэг хянан шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхүүд эрүүгийн 2016, иргэний 2102, захиргааны зөрчлийн 205 бүгд 4323 хэрэг хянан шийдвэрлэжээ. Аймгийн шүүхийн нэг шүүгч дунджаар 25, нийслэлийн шүүхийн нэг шүүгч дунджаар 129 хэрэг хянан шийдвэрлэсэн байна.

Хяналтын шатны шүүх буюу Улсын Дээд шүүх иргэний 1025, эрүүгийн 551, захиргааны 324, давж заалдах журмаар 521 нийтдээ 2421 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Дээд шүүхийн нэг шүүгчид дунджаар иргэний хэрэг 205, эрүүгийн хэрэг 137, захиргааны 140 хэрэг ногдож байна.

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
СУДАЛГААНЫ ТӨВИЙН
ЗАХИРАЛ

Ч.НЯМСҮРЭН

ШҮҮХИЙН СТАТИСТИК,
ТООН МЭДЭЭЛЭЛ
ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

Д.ОЮУНЧИМЭГ